



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

“БИНСЭ” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 25, 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “БИНСЭ” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,268,320 /нэг сая хоёр зуун жаран найман мянга гурван зуун хорь/ ширхэг хувьцаанд хаалттай хүрээнд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог 1,000,000 /нэг сая/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,268,320 /хоёр сая хоёр зуун жаран найман мянга гурван зуун хорь/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгох үнийг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр уг эрхийг хэрэгжүүлэх ажлыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш хуульд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “БИНСЭ” ХК /Б.Батзаяа/-д тус тус үүрэг болгосугай.

3. “БИНСЭ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй үлдсэн хувьцаанаас иргэн Б.Батзаяагийн “БИНСЭ” ХК-д олгосон нийт 200,000,000 /хоёр зуун сая/ төгрөгийн зээлийн төлбөрт нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 200,000 ширхэг хувьцааг эзэмшүүлж, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 300,000 ширхэг хувьцааг хаалттай хүрээнд энэхүү тогтоолын хавсралтад заасан нэр бүхий хөрөнгө оруулагчдад компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр худалдахаар санал болгохыг зөвшөөрсүгэй.

4. “БИНСЭ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг худалдан авах хүсэлтийг хүлээн авч дуусгах, нэгдсэн бүртгэл гарган худалдан авсан үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх, үлдсэн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, “БИНСЭ” ХК /Б.Батзаяа/-д тус тус үүрэг болгосугай.

5. Тус компанийн нэмж үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “БИНСЭ” ХК /Б.Батзаяа/, “Нэйшнл секюритис ҮЦК” ХХК /Б.Баярсайхан/-д тус тус үүрэг болгосугай:

010070

1/ Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж үнэт цаас гаргах шийдвэр гаргасантай холбогдуулж нийт хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;


2/ Нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох баримт материалын хамт Хороонд ирүүлэх;

3/Эргэлтэд гараагүй үлдсэн хувьцааг зах зээлд байршуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэх.

6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “БИНСЭ” ХК /Б.Батзаяа/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА